



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/354

Булган сум

Газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 29 дүгээр зүйлийн 29.10.2, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн IX/19 дүгээр тогтоолоор баталсан “Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн О.Батцэнгэл (ГЭ88040119)-ийн Булган сум 5 дугаар баг Анхдагчдын өргөн чөлөө 1 дүгээр гудамж 113а тоотод байршилтай 6308003739 нэгж талбар бүхий орон сууцны зориулалттай 105 м2 газар нь Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд авто зам тавигдахаар төлөвлөгдсөн тул Булган сумын 6 дугаар баг Залуус 1 дүгээр гудамж 102а тоотын ар талд байршлыг өөрчлөн 1 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газрын кадастрын мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг хийж, газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

